

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан .....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл .....	8
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ....	9
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	11
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	11
3	Менежментийн захидал .....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	17
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан .....	0

## Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

БАГАБАЯН ЭНХИЙН ТӨЛӨӨ  
ЦОГЦОЛБОР ТӨВ ТӨААТҮГ-ЫН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ, ХУРАНДАА  
Д.БАТБААТАР ТАНАА

2019.03.25 № 06/572  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын Ерөнхий захирал, хурандаа Д.Батбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тусгасан.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд оруулсан.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын удирдлага Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 20-ноос 2019 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн аудитор А.Цэрэнчимэд, аудиторын туслах Б.Анармаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ 2018 оны санхүүгийн тайланг Стандарт дүгнэлт аудит ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 35/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨҮГ нь “Батлан хамгаалах салбарын цэргийн алба хаагчид, өндөр настан, ахмад дайчид Монгол улсын болон гадаадын энхийг сахиулагчид, цэргийн алба хаагчид, зочид амрагчдад сэтгэл ханамжтай үйлчилгээ үзүүлэх, аялал, жуулчлалыг хөгжүүлэх, батлан хамгаалах салбарын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах, Монгол Улсын болон олон улсын жишиг стандарт /MNS4958:2000/-д нийцсэн амралтын үйлчилгээг үзүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан Бизнес төлөвлөгөөнд Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний удирдлагаас дэвшүүлсэн зорилго, зорилтыг ханган биелүүлж, удирдлага, зохион байгуулалт, амралт үйлчилгээний зөв менежментийг хэрэгжүүлэх,
- Амрагчдын ая тухтай, үйлчилгээний соёлч, шуурхай байдал, амралтын орчны эрүүл ахуй, тохьжилтыг Монгол Улсын болон олон улсын жишиг стандарт MNS4958:2000-д нийцүүлсэн өндөр түвшинд хүргэх,

- Ашиг, орлогоо нэмэгдүүлэх, үр ашиггүй зардлыг багасгах, санхүүгийн бүртгэл тооцоог сайжруулах, 2018 оны бараа материал хүнсний материал худалдан авах төлөвлөгөөг боловсруулж, “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуульд нийцүүлж, сонгон шалгаруулалт, тендерийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх,
- Ажилчин албан хаагчдын хөдөлмөрийн сахилга бат, ажлын хариуцлага, гүйцэтгэх чадвар, хууль эрх зүйн мэдлэг, харьцааны соёл, мэргэжлийн боловсролыг дээшлүүлэх,
- 2016 оноос 2020 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөгүй ажил, үйлчилгээ явуулах

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын болон Нийгмийн даатгалын багц хуулиуд

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Emerald” програм хангамж ашигладаг байна.

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Байгууллагын удирдлага, ерөнхий нягтлан бодогч нарын зүгээс санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтыг сулруулснаас нягтлан бодох бүртгэлийн анхан шатны зарим маягт бүртгэл, батлагдсан маягт аргачлалын дагуу хөтлөгдөөгүй, төсөвт төвлөрүүлэх ёстой татварын орлогыг бүрэн тооцож, тайлагнаагүй, өөрийн харьяанд үйл ажиллагаа явуулдаг Ахмадын сувиллын бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээг огт хянаж, чадаагүй гэдгийг удирдлагууд бичгээр тайлбар гаргаж өгсөн.

Эдгээр хариуцлагагүй үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэл, тайлагнал холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тайлагнахад эрсдэл учруулж байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант хугацааны нийт зардлын дүнг сонгов.

Тайлант хугацааны нийт зардлын дүнг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт зардал санхүүгийн тайлагналын үндсэн үзүүлэлт гэж үзсэнтэй холбоотой.

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2018 оны нийт зардлын дүн 1,568.2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 31.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь өмнөх аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан, төлөвлөлтийн шатанд эрсдэлийн үнэлгээний түвшин дунд гэж тодорхойлогдсонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.



## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

### 2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга гараагүй болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

### 2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	1,7	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	2,0	
3	Албан шаардлага өгсөн	1	4,4	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн			
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн			
	Дүн	5	8,1	

#### 2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### Асуудал 1. Балансын данстай холбоотой асуудал

Тус компанийн амралтанд амарсан энхийг сахиулагч нарын төлбөрийн тооцоогулган шалгахад 4.4 сая төгрөгийг Батлан хамгаалах яамны Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас дутуу авсан байна.

Энэ нь (Үнэн зөв байдал) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: ...14.4.2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;” 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Батлан хамгаалах яамны Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас авах 4,4 сая төгрөгийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай тооцоо нийлж, баталгаажуулан, авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

#### **Асуудал 2. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт**

Тус компанийн малчин Д.Насан зохих зөвшөөрөл шийдвэргүй компанийн малаас 177 хонийг 177 ямаагаар сольсноос 2.0 сая үнийн зөрүү гарч компанид хохирол учруулсан байна.

Энэ нь (Үнэн зөв байдал) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана.” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: ...14.4.2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;” 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчжээ.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Малын үнийн зөрүү 2.0 сая төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлж, төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

#### **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын удирдлага, үйл ажиллагаанаас үл хамаарах дээд байгууллага, албан тушаалтнуудын шийдвэрээр тус компани алдагдал

хүлээх, дотоод хяналт сулрах зэрэг санхүүгийн тайланд цаашид материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй асуудлыг дор дурдав. Үүнд:

- Тус компани 2018 онд дээд байгууллагын 6 удаагийн чиглэл даалгаврын дагуу тэдний явуулсан зочдыг үнэ төлбөргүй хүлээн авч үйлчилсэн зардал 13.8 сая төгрөгийг Зэвсэгт хүчний хөгжлийн санд төвлөрүүлэх орлого болгож тооцсноос гадна тус санд харилцахаас 50.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Зэвсэгт хүчний хөгжлийн санд харъяа байгууллагаас хөрөнгө төвлөрүүлэх эрх зүйн үндэслэл байгаа эсэх, төвлөрүүлсэн хөрөнгийн зориулалт, зарцуулалт хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгах
- Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын дэргэд тэдний хөрөнгөнд түшиглэн Батлан хамгаалах яамны Ахмадын амралт давхар ажиллуулж байна. Ахмадын амралтын удирдлага тус компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Ахмадын амралт санхүү аж ахуйн үйл ажиллагаагаа тусдаа явуулж, санхүүгийн тайлангаа тус компанид нэгтгүүлдэг бөгөөд бэлэн мөнгөний гүйлгээ тус компанийн хяналтаас гадуур явж ирсэн байна. Ахмадын амралт нэгэнт тус компанийн хөрөнгөнд түшиглэн үйл ажиллагаа явуулж байгаа тул тусдаа удирдлагын бүтэц байх шаардлагагүй бөгөөд Ахмадын амралтын удирдлагын илүү бүтэц орон тоог цомхтго асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна.
- Энхийг сахиулагч нарыг тус амралтанд амраах үнийн тариф баталсан шийдвэр байхгүй бөгөөд аман шийдвэрээр бодит өртөгөөс 2 дахин бага үнээр амрааж, тооцоо хийж ирсэн байна. Энэхүү алдагдлыг тус компани хүлээсээр ирсэн байна. Иймд энхийг сахиулагч нарын үнийн тарифыг бодитой тогтоож, баталгаажуулах асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна.
- Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/370 дугаар тушаалаар тус компанийн 3.0 сая төгрөгийн авлагыг хүчингүй болгосон байна. Энэхүү өглөг, авлагыг сайдын тушаалаар хүчингүй болгох боломжтой эсэх

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц эрсдэлтэй асуудлыг дор дурдав. Үүнд:

- Тус компанийн нүүрс татан авалт, зарцуулалт, түүнд бүртгэлээр тавих хяналтыг зохион байгуулсан байдал
- Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, түүний зохион байгуулалт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

## **2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2018 оны бизнес төлөвлөгөөгөөр 2018 оны нийт орлогыг 1,325.3 сая төгрөг, зарлагыг 1,261.9 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Батлагдсан орлогын төлөвлөгөөг 24.66 хувь буюу 310.6 сая төгрөгөөр давуулсан, зарлагыг 24.66 хувь буюу 311.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Батлагдсан зардлыг хэтрүүлэн зарцуулахад түүхий эд материалын зардлыг 35.37 хувиар, хөдөлмөр хамгааллын зардлыг 119.16 хувиар, цалингийн зардлыг 27.42 хувиар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 131.05 хувиар, бусад зардлыг 134.98 хувиар тус тус хэтрүүлсэн зарцуулсантай холбоотой байна.

Орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн нь амрагчдын тоо өссөнтэй холбоотой бөгөөд тэдэнд үйлчилгээ үзүүлэхэд түүхий эд материалын зардал тэр хэмээжээр нэмэгдэх шалтгаан болжээ. Зардал хэтрэхэд ажилчдын хувцасыг бүрэн шинэчилсэн, дээд байгууллага албан тушаалтны шийдвэрээр хөнгөлөлттэй амрагчдын төлөвлөгдөөгүй зардал өртөлт шингэдэг, Зэвсэгт хүчний хөгжлийн санд хөрөнгө төвлөрүүлдэг нь нөлөөлсөн байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус газар дээрх хуулийн дагуу төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 7, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 5, бусад 6 төрлийн мэдээллийг оруулах мэдээллийг бүрэн оруулсан байна. Харин Шилэн дансны цахим хуудсанд оруулах зарим мэдээллийг 26 удаа хугацаа хоцроосон байна.

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-т цахим хуудас байхгүй тул шилэн дансны хуулийн хэрэгжилт, оруулсан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд түгээх боломжгүй байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 90 хувьтай байна.

Өмнөх аудитаар байгууллагын удирдлагын үйл ажиллагааг хэрхэн үнэлэх, зардлын төсөв төлөвлөгөөг зохих журмын дагуу баталгаажуулан мөрдөж ажиллах хөрөнгийг зөв ангилж бүртгэх тухай 3 зөвлөмж бүрэн хэрэгжиж тодорхой үр дүнд хүрсэн байна.

Харин хүчин төгөлдөр, иж бүрэн анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийх, шатахууны тооцоог үнэн зөв хийх тухай 2 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

##### 3.1.1 Илрүүлэлт:

Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын байршиж байгаа газар нь гэрчилгээгүй, газрын төлбөр төлж байгаагүй байна. Иймд газрын үнэлгээ хийгдээгүй байна.

Энэ нь (**Үнэн зөв байдал** - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Газрын төлбөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлд “Газрын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу гэрээ байгуулан газрыг эзэмшиж, ашиглаж байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, ..... газрын төлбөр төлөгч байна.” 9 дүгээр зүйлийн 9.2-т “Газрын төлбөр төлөгч нь газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд өөрөөр заагаагүй бол жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улирал бүрийн эхний сарын 25-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.” Гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Төсвийн өмнө хүлээх үүргийн биелэлт хангагдахгүйд хүрч, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлээгүй байх

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Загсийн газрын 2016 оны 193 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах шийдвэр гарсан тул өөрийн байршиж байгаа газрыг эзэмших, ашиглах эрхийг хууль тогтоомжид нийцүүлэн баталгаажуулж, газрын төлбөрийг зохих журмын дагуу төсөвт төвлөрүүлэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх

### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

## **3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа**

### **3.2.1 Илрүүлэлт:**

Тус компани тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй хураангуй бүртгэлийг батлагдсан маягт аргачлалаар бүртгэж, баталгаажуулалгүй бүртгэл тайланд тусгасан нь нягтлан бодох бүртгэл хөтлөх дарааллыг алдагдуулж, бүртгэлээр хяналтыг сулруулсан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 3.5-д *“Бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг тухай бүрд мэдэх, түүний бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор агуулахын бүртгэлийг эд хариуцагч материалын нэр төрөл, зэрэг, дугаар бүр дээр нээж хөтөлнө. Агуулахын бүртгэлийг дэвтэр маягтаар хөтөлнө. Түүний хуудас нэг бүрийг дугаарлан, хуудасны тоог тавьж хариуцагч нягтлан бодогч нь эд хариуцагчид жилийн эхэнд хүлээлгэн өгнө. Материал, үнэ бүхий зүйлийн хөдөлгөөнийг эд хариуцагчид “Бараа, материалын үнэ бүхий зүйлийн орлого, зарлагын баримт”-ийг үндэслэн агуулахын бүртгэлийг биет нээжээр хөтөлж өдөр тутмын үлдэгдлийг тодорхойлохын хамт тайлант хугацаанд хариуцагч нягтлан бодогчоор тайлангаа хянуулж үлдэгдлийг батлуулан гарын үсэг зуруулна. Агуулахын бүртгэлийн хуудас бүрийг дугаарлаж, эцсийн хуудсанд нягтлан бодогч нийт дугаарын тоог тавьж, санхүүгийн тэмдэг дарна.”* гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Энэ нь **(Үнэн зөв байдал** - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан журам, аргачлалын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

### **3.2.2 Эрсдэл:**

Анхан шатны баримтын бүрдүүлэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтөд шат шатны хяналтыг өдөр тутам хэрэгжүүлээгүй нь бүртгэлээр тавих хяналт суларч, нягтлан бодох бүртгэлийн уялдаа алдагдах, тайлан тодруулга алдаатай илэрхийлэгдэх шалгаан болж байна.

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим, 14 дүгээр зүйлд заасан дарааллын дагуу

шаардлагад нийцсэн анхан шатны баримтад үндэслэн дэлгэрэнгүй хураангуй бүртгэлийг батлагдсан маягт аргачлалаар хөтөлж, тайлагнах нөхцөлийг бүрдүүлж ажиллах

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

## **3.3 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт**

### **3.3.1 Илрүүлэлт:**

Тус компани 2018 онд бэлэн мөнгөөр 9.9 сая төгрөг, бэлэн бусаар 7.3 сая төгрөгийг хувь хүнд бараа материал, үйлчилгээний үнэнд шилжүүлсэн боловч 1.7 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь (Үнэн зөв байдал) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т *"хувиараа ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр олсон үйлдвэрлэл, арилжааны орлого"*, 23 дугаар зүйлийн 23.2.4-д *"энэ хуулийн 18, 19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар;"* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.7-д *"аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах"* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

### **3.3.2 Эрсдэл:**

Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт хангагдахгүй байх

### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Хувь хүний орлогын албан татварын дутуу ногдуулсан 1.7 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлэх, цаашид энэ төрлийн дутагдлыг давтан гаргахгүй байх

### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2017-12-31	2018-12-31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	45,272,044.98	62,065,974.80
1.1.2	Дансны авлага	117,769,969.42	115,690,553.73
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	436,028.04	556,374.12
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	269,412,645.69	292,865,448.47
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	1,301,381.40
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	20,653,506.51	22,380,465.66
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>453,544,194.64</b>	<b>494,860,198.18</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,569,599,051.39	3,607,088,961.17
1.2.2	Биет бус хөрөнгө	1,977,477.57	4,551,303.30
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,571,576,528.96</b>	<b>3,611,640,264.47</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,025,120,723.60</b>	<b>4,106,500,462.65</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>	-	-
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.1.1	Дансны өглөг	19,898,624.72	34,406,120.55
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	90,665,067.49	14,633,442.96
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	736,300.00	-
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	3,467,800.00	4,776,556.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12	НХАТ өглөг	1,036,065.04	3,493,851.65
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>115,803,857.25</b>	<b>57,309,971.16</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	-	-
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>115,803,857.25</b>	<b>57,309,971.16</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>943,008,420.00</b>	<b>943,008,420.00</b>



2.3.1	Өмч: - төрийн	943,008,420.00	943,008,420.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,558,676.16	2,095,895,116.30
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	580,892,169.99	580,892,169.99
2.3.9	Хуримтлагдсан ашиг	372,857,600.20	429,394,785.28
2.3.10	Тайлант үеийн ашиг/алдагдал	-	-
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>1,909,316,866.35</b>	<b>4,049,190,491.57</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,025,120,723.60</b>	<b>4,106,500,462.73</b>

**4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>1,111,992,878.67</b>	<b>1,486,144,102.61</b>
2	Борлуулалтын өртөг	892,332,134.89	1,155,275,043.25
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>219,660,743.78</b>	<b>330,869,059.36</b>
4	Түрээсийн орлого	23,098,424.99	272,727.27
5	Хүүний орлого	650,378.28	646,474.32
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Хөрөнгөөрх орлого	89,998,986.00	49,551,197.64
8	Бусад орлого	51,874,955.39	99,252,534.59
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	10,748,827.81
10	Ерөнхий ба удирдлагын зардал	248,557,954.36	308,161,487.37
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	43,075,097.06	93,992,467.04
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(17,342,117.68)	(4,873,049.48)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	<b>76,308,319.34</b>	<b>62,816,161.48</b>
19	Орлогын татварын зардал	7,630,831.93	6,281,616.14
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>68,677,487.41</b>	<b>56,534,545.34</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	68,677,487.41	56,534,545.34
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>68,677,487.41</b>	<b>56,534,545.34</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

**4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,283,695,766.91	1,705,285,106.48
	Бараа борлуулсан,ажил үйлчилгээний орлого	1,197,288,701.36	1,613,693,637.85
	Буцаан авсан албан татвар	84,679,394.97	84,199,123.18
	Бусад мөнгөн орлого	1,727,670.58	7,392,345.45
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,293,673,717.62	1,689,137,650.38
	Ажиллагчдад төлсөн	210,450,354.00	240,884,822.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	78,799,085.25	107,701,877.47
	Бараа материал худалдан авахад төлсөн	777,010,657.65	936,325,682.06
	Ашиглалтын зардалд төлсөн	81,383,250.91	37,367,194.54
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,856,903.82	6,680,519.09
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	89,012,781.84	188,363,306.00
	Даатгалын төлбөрт төлсөн	108,500.00	666,090.00
	Бусад мөнгөн зарлага	47,052,184.15	171,148,159.22
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(9,977,950.71)</b>	<b>16,147,456.10</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	650,378.28	646,474.32
	Хүлээн авсан хүүний орлого	650,378.28	646,474.32
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>650,378.28</b>	<b>646,474.32</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
	<b>Валютын ханшийн зөрүү</b>	-	-
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(9,327,572.43)</b>	<b>16,793,929.82</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>54,599,617.41</b>	<b>45,272,044.98</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>45,272,044.98</b>	<b>62,065,974.80</b>

#### 4.4 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуригтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2016-12-31-ний үлдэгдэл</b>	<b>943,008,420.00</b>		-	<b>12,558,676.16</b>		<b>580,892,169.99</b>	<b>304,180,112.79</b>	<b>1,840,639,378.94</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						68,677,487.41	68,677,487.41	
9	<b>2017-12-31-ний үлдэгдэл</b>	<b>943,008,420.00</b>	-	-	12,558,676.16	-	580,892,169.99	<b>372,857,600.20</b>	<b>1,909,316,866.35</b>
10	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						2,639.74	2,639.74	
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	943,008,420.00	-	-	12,558,676.16	-	580,892,169.99	372,860,239.94	1,909,319,506.09
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						56,534,545.34	56,534,545.34	
14	Өмчид гарсан өөрчлөлт				2,083,336,440.14				2,083,336,440.14
17	<b>2018-12-31-ний үлдэгдэл</b>	943,008,420.00	-	-	2,095,895,116.30	-	580,892,169.99	429,394,785.28	4,049,190,491.57

## Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2019-03-14

Аудитын нэр:

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код:

САГ-2019/24/СТА-ТӨҮГ

Шалгагдсан байгууллагын нэр:

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ

Сая төгрөгөөр

№	Аудитын зорилт, чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
<b>A</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>			<b>9</b>	<b>10</b>
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа	Нягтлан бодох бүртгэл хөтлөх дарааллыг алдагдуулж, агуулахын бүртгэл хөтлөлгүй ажил гүйлгээ хийж байсан нь бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.		Зөвлөмж өгөх			Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Хурандаа Д.Батбаатар, Д.Дэлгэрмаа
2	Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт	Тус компани 2018 онд 17,142,240.00 төгрөг хувь хүнд бараа материал, үйлчилгээний үнэнд шилжүүлсэн боловч 1,714,224.00 төгрөгийн Хувь хүний орлогын албан татвар суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.	1,7	Зөвлөмж өгөх			Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Хурандаа Д.Батбаатар, Д.Дэлгэрмаа

Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

3	Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт	Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын байршиж байгаа газар нь гэрчилгээгүй, газрын төлбөр төлж байгаагүй байна.		Зөвлөмж өгөх			Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Хурандаа Д.Батбаатар, Д.Дэлгэрмаа
4	Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт	Тус компанийн малчин Д.Насан зохих зөвшөөрөл шийдвэргүй компанийн малаас 177 хонийг 177 ямаагаар сольсноос үнийн зөрүү гарч компанид хохирол учруулсан байна.	2,0	Төлбөрийн акт тогтоох			Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Хурандаа Д.Батбаатар, Д.Дэлгэрмаа
5	Балансын данстай холбоотой асуудал	Тус компанийн амралтанд амарсан энхийг сахиулагч нарын төлбөрийн тооцоог тулган шалгахад 4,389,000.0 төгрөг Батлан хамгаалах яамнаас дутуу авсан байна.	4,4	Албан шаардлага өгөх			Багабаян Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Хурандаа Д.Батбаатар, Д.Дэлгэрмаа
		Дүн	8,1					



